



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2022.04.05 № 13

Асуулт тавих тухай

Дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын улмаас Монгол Улсын эдийн засаг 1992 оноос хойших хамгийн гүн хямралд орж 2020 онд 4.6 хувиар агшсан байна.

Гадаад, дотоод худалдаа, үйлчилгээ нээгдэж, эдийн засаг аажмаар сэргэж байгаа ч олон улсын хямралт нөхцөл байдлаас шалтгаалан инфляцийн түвшин тасралтгүй нэмэгдэж, төгрөгийн ам.доллартай харьцах ханш огцом суларч, банкууд ам.долларын арилжаанд тодорхойгүй хугацаанд хязгаарлалт тогтоогоод байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт тус тус заасныг үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:


1. Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн ханшийн сулралыг тогтоон барих, тухайлбал ам.долларын ханшийн огцом өсөлттэй холбоотойгоор авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар;

2. Банкууд харилцагч нартаа олгох валютын лимит ямар хугацаанд үргэлжлэх болон гадаад худалдаа эрхлэгч, импортлогч аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн төлбөр, тооцооны асуудалд ямар зохицуулалт хийж байгаа зэрэг асуудлаар тодорхой мэдээлэл өгнө үү.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН



Х.ГАНХУЯГ